

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Эхийг анхааралтай уншиж, ойлгоод даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
3. Эхээс сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
4. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой. (Даалгавар бүр 2 оноотой)

Хавар

*Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар
Монголын сайхан оронд жил жил дэлгэр
Энх улирал ханхлахад хүний сэтгэл тэнгээр
Өвсний соёо ногоороход морь мал ханагар
Холхи нар ойртож, хасын цас хайлахад
Хуучин дэлхий халагдаж, хамаг юм шинэчлэгдэнэ
Хөхөрсөн модон цэцэглэж, хүүхэд багачууд наадахад
Хөгшин хүн өөрийгөө залуу болсон шиг санана
Хээрийн галуу айлчлан ирж, гангар гунгар донгодоход
Гэртээ суусан малчин түүнийг чагнан уярна
Хажуу дахь уулнаа горхи булаг хоржигнон урсахад
Хаяан дахь хурга ишиг майлалдан, хөгжим нийлүүлнэ
Эелдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд
Эрт эдүгээг бодогдуулан, нуугдсан сэтгэлийг сэргээнэ
Өнөр сайхан төл баян хотыг чимэхэд
Өлгийтэй бяцхан хүүхэд, эцэг эхээ баясгана (Д.Нацагдорж)*

1. Эх нь тоочимж болохыг баталсан хэсгийг олоорой.
 - A. Хэрэг явдлыг өнгөрсөн, одоо, ирээдүй гурван цагт хүүрнэн бичжээ.
 - B. Хэрэг явдлын бодомжийн харьцаанаас шинэ дүгнэлт гаргажээ.
 - C. Юмс үзэгдлийн гол шинжийг нарийн дэс дараалалтай зураглан бичжээ.
 - D. Агуулга нь баримт жишээнд тулгуурлажээ.
 - E. Шалтгаан, үр дагавар, дүрэм тодорхойлолтод тулгуурлажээ.
2. **“Эцэг эхээ баясгана.”** гэсэн өгүүлбэрийн өгүүлэхүүнийг захирах өгүүлбэрийн өгүүлэхүүн болгон хувиргасан хэсгийг олоорой.

A. баясга B. баясгадаг уу C. баясгав D. баясгах уу E. баясгалаа даа
3. Цөм үг нь жинхэнэ нэрээр илэрсэн холбоо үгийг олоорой.

A. сэтгэл тэнгэр B. бяцхан хүүхэд C. сэтгэлийг сэргээх
D. чагнан уярах E. ариухнаар үнэртэх
4. **“Энх улирал ханхлахад хүний сэтгэл тэнгээр”** гэсэн өгүүлбэрийг шууд утга санаагаар хувиргасан хэсгийг олоорой.
 - A. Хайр дурлал хаврын бороо цэцэгнээс эхэлнэ.
 - B. Хайртай аавыг минь байхад хаврын өдрүүд өнгөтэй байлаа.
 - C. Хавар, хэвлийдээ тийчилсэн яргуйг элгэн дээрээ бүүвэйлнэ.
 - D. Хавар болоход хүмүүс дуртай байдаг.
 - E. Хаврын улирал айлчлахад торгон салхи сэвэлзэнэ.

16. “Өлгийтэй бяцхан хүүхэд эцэг эхээ баясгана.” гэсэн өгүүлбэрийн дэлгэрүүлэгч гишүүнийг зөв салаалан хувиргасныг олоорой.
 А. аав ээжээ В. баярлуулна С. манцуйтай жаахан D. үр E. жаал
17. Аль хэсэг нь эхэд хүний дотоод сэтгэлийн өөрчлөлт хувирлыг илэрхийлээгүй вэ?
 А. Хүний сэтгэл тэнэгэр В. Хүүхэд багачууд наадахад С. Залуу болсон шиг санана
 D. Түүнийг чагнан уярна E. Нуугдсан сэтгэлийг сэргээнэ
18. “Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар” гэдгийг “Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар ирлээ.” гэж хувиргавал эхийн найруулгад өөрчлөлт гарах уу?
 А. Үг буруу сонгосон алдаа болно. В. “Ирлээ” гэвэл эсрэг утгатай болох тул оновчгүй.
 С. Үг дутсан алдаа болно. D. “Хавар ирлээ.” гэдэг нь учир зүйн алдаа.
 E. Үг илүүдэж шүлгийн айзам хэмнэл алдагдана.
19. Хаврын улиралд холбогдолгүй хэсгийг олоорой.
 А. Энх улирал В. Хуучин дэлхий С. Урьхан амьсгал D. Өвсний соёо E. Эелдэг амьсгал
20. Эхэд ойролцоо утгаар хэрэглэсэн үгсийг олоорой.
 А. халагдах – шинэчлэгдэх В. ханхлах – ногоорох С. ойртох – хайлах
 D. донгодох – уярах E. үнэртэх – сэргээх
21. “шинэчлэгдэнэ” гэдгийн утгат хэсгийг зөв тайлбарласныг олоорой.
 А. шинэ – идэвхгүй язгуур, үгийн үндэс
 В. шинэч – идэвхтэй язгуур, нэрийн үндэс үүсгэх дагавар авсан
 С. шинэчил – идэвхтэй язгуур, үйлийн үндэс үүсгэх дагавар авсан
 D. шинэчлэгд – үүсмэл бус үйл үг, нэр үг бүтээх дагавар авсан
 E. шинэчлэгдэнэ – үүсмэл бус үйл үг, үйлдэгдэх хэв, биеэр төгсгөх нөхцөлтэй.
22. Өгүүлбэрийн цэгийн оронд орны нэрийг тохируулан нөхөөрэй.
Байшингийн дээвэр маш балтгар. Байшингийн өдөр байтлаа, бүрий барай байдлыг төрүүлнэ. (Д.Н)
 А. дотор В. цонх С. дээвэр D. хана E. өнөөдөр
23. Дараах хэлзүйн тайлбарт тохирох үгийг олоорой.
 Үйл үг, үүсмэл, өөрөө үйлдэх хэв, энгийн үйлдэх байдалд байгаа, хам холбох нөхцөл (үйлийн тийн ялгалын хам хэлбэр) - тэй
 А. ногоорох В. наадахад С. айлчлан D. нийлүүлэн E. үнэртээд
24. Дараах таван үгээс төрөл биш утгат үгийг олоорой.
 А. санал В. сандал С. санаа D. санамсаргүй E. санаачил
25. Эхийн дараах хэсэгтэй ойролцоо санаат өгүүлбэрийг олоорой.
**Мөнх тэнгэрийн дор мянга мянган хавар
 Монголын сайхан оронд жил жил дэлгэр**
 А. Хаврын сүүл сар хүн бүхний сэтгэлийг хөдөлгөсөн сайхан өглөө байв. (Д.Н)
 В. Өвлийн хүйтнийг адуу манаж өнгөрүүлэн, зуны халууныг хонь хариулж гэтэлгэх бөгөөд намар ичиж хавар гарагч тарваганаас зовлонтойгоор он жил нөхцүүлнэ. (Д.Н)
 С. Тааламжтай сайхан хавар, найртай сайхан хавар Дахин дахин ирж дэлхий дахиныг гийгүүлнэ. (Д.Н)
 D. Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин. (Д.Н)
 E. Хаврын хурц наранд өвлийн хунгарласан цас хайлж, газрын хөрсийг чийгтүүлнэ. (Д.Н)
26. Дараах хэсэгт нутгийн аялгууны үг хэрэглэснийг хэрхэн дүгнэх вэ?
**“Ая шамдаа л адил басганыг би
 Онон худар эрээд эрээд
 Олохгүйб даа” гэж
 Омголон залуу санаа алдана. (P.Ч)**

- A. Нутгийн аялгууны үгс нь утга ойлгомжгүй, тодорхойгүй байгаа тул аль ч найруулгад хэрэглэхгүй.
 B. Зохиолын баатрын дүрийг тодруулах үүргээр уран зохиолын найруулгад хэрэглэнэ.
 C. Утга зохиолын хэлэнд идэвхтэй хэрэглэдэг үгсийг буруу хэрэглэсэн жишээ
 D. Аль ч найруулгад үүнийг чөлөөтэй хэрэглэж болох тул дээрх үгс нь зөв найруулгын жишээ
 E. Зөвхөн эрдэм шинжилгээний найруулгад хэрэглэдэг тул дээрх нь найруулгын алдаа мөн.
27. Дараах хэсгийн тодруулсан бүтээврийн (- хан⁴) баймж утгатай хамгийн ойр хэсгийг олоорой.

Эелдэг урьхан амьсгал ариухнаар үнэртээд

Эрт эдүгээг бодогдуулан нуугдсан сэтгэлийг сэргээнэ

- A. Хөвсгөрхөн цагаан үүл нь хөвөлзөнхөн нүүдэллэнэ.
 B. Тавьхан лангийн үнэтэй миний ээж хаачив?
 C. Жижигхэн гацуурхан өвөл хүйтэн байна даа
 D. Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би
 E. Аавгүйхэн ботго нь араар тэнээд буйлна

28. Дараах өгүүлбэрийн утга санааг эсрэг санаагаар солин найруулахад цэгийн оронд дарааллаараа тохирох хэсгийг ол.

Олонд тус хүргэгчдийн бие амар

Олонд тус ... хүргэгчдийн бие амар...

- A. битгий, на B. маш, аарай C. бас, жээ D. тас, лаа E. үл, хгүй

29. Утга төгс өгүүлбэр бүтээхэд, цэгийн оронд аль бүтээвэр нь дарааллаараа тохирох вэ?

Өглөөний хяруу сувд..... адил гялт н буурал....на.

- A. - тай,- л,-жээ B. -аар ,-аа, -аарай C. -ын,- гана,- т D. -аар, -га, -ц E. -шиг,- лз, -даг

30. “- хө” - г хөгжин хөхих, магтан сайшаах баймж утгат өгүүлбэрт хэрэглэснийг олоорой.

- A. Агт морио уная гэвэл
 Арчлан гамнаж унах юм шүү хө.
 B. Улаан минчүү дээл нь
 Уулын харгананд урагдана даа хө.
 C. Түүхий дээл нь түргэн дээ, түргэн амраг сална даа хө.
 D. Дунд голын ногоо нь хө, ургасан байтлаа тарьсан юм шиг ээ хө.
 E. Улаан торгон цамцыг ээ хэндээ ч гэж оёхов дээ хө.

31. Дараах хэсэгт өгөх оршихын тийн ялгалын нөхцөлтэй үг хэд байна вэ?

Энх улирал ханхлахад хүний сэтгэл тэнэгэр

Өвсний соёо ногоороход морь мал ханагар

- A. 2 B. 3 C. 4 D. 5 E. 1

32. Цэгийн оронд зөв бичгийн дүрмийн алдаагүй үгийг нөхөж бичээрэй.

Тэнгэрийн муухай гэртээ харина.

- A. арилхаар B. арилахаар C. арлихаар D. арилихаар E. аралихаар

33. “Өвсний соёо ногоороход морь мал ханагар.” гэсэн өгүүлбэрт харьяалахын тийн ялгалын нөхцөл ямар утгатай байна вэ?

- A. Оноосон нэр онцлох B. Юмын чанар C. Бүхлийн хэсэг
 D. Шалтгааны утга E. Цаг хугацаа

34. Ц.Дамдинсүрэн “Чемодантай юм” өгүүллэгийн Цээмаагийн дүрийг тодорхойлсныг олоорой.

- A. Хал нь гаднаа, хайр нь дотроо
 B. Хэлэн дээр нь чихэр, шилэн дээр нь хутга
 C. Хүн болох багаасаа хүлэг болох унаганаасаа
 D. Хорлох дайсны хориул, халдах дайсны халхавч
 E. Харийн газар нэрээ, өөрийн газар ясаа

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР**Санамж:**

1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.
2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноотой

2.1. Хэлцийн утгыг тунгаан цэгийн оронд тохируулан харгалзуулаарай.

- | | |
|--|--|
| a. Бадарчийн барзгар нүүрэнд саран хайнагийн бүдүүн дуугаар орчмын бургасыг донслуулан инээв. (Ч.Л) | 1. арсланг саваагаар алж |
| b. Итгэлтийн ширүүн үгэнд байгаа Должинг шоолон, хорслын баяр бахдалаар сэтгэл нь дүүрч байлаа. (Ч.Л) | 2. шуналын гал манаран оволзож |
| c. Тамгын газар заргалдвал залан авгайн ганц жинс нь манай хотын гурван айлаас мэдэх л хэрэг гэж инээлдэв. (Б.Р) | 3. ачаа хүндэдсэн тэмээ шиг шургачин бууж өгч |
| d. Заяагдсан амьдралаас хэтэрч хагартал мөргүүлэх шахав гэж боддог болсон. (Ч.Л) | 4. илүү жинтэй болчхож |
| e. Цагийг нь олж цохивол болно гэж боддог хүн юм. (Ч.Л) | 5. бяруу болоогүй байж бухын хэрэлтээр хэрснээс болж |

2.2. Оновчтой харгалзуулан дүрслэх ур маяг бүхий холбоо үг бүтээгээрэй.

- | | |
|------------|-----------|
| a. Эцэг | 1. зам |
| b. Эрдэнэт | 2. гэгээ |
| c. Сүүн | 3. тал |
| d. Буурал | 4. тэнгэр |
| e. Бор | 5. хүн |

2.3. Нэг зохиолчийн хоёр бүтээлийг харгалзуулаарай.

- | | |
|-------------------------------|------------------------------|
| a. “Учиртай гурван толгой” | 1. “Нууцыг задруулсан захиа” |
| b. “Өвгөн шувуу” | 2. “Ламбагуайн нулимс” |
| c. “Манай сургуулийнхан” | 3. “Хоёр цагаан юм” |
| d. “Хэлдэг гурав хийдэг ганц” | 4. “Тунгалаг тамир” |
| e. “Шүхэрч Буниа” | 5. “Наран тогоруу” |

2.4. Дараах үгсийг утгын тайлбартай нь зөв харгалзуулаарай.

- | | |
|-------------------|--|
| a. Дээлийн оноо | 1. Дээлийн ханцуйн үзүүрт дээш сөхөн залгасан чимэглэл |
| b. Дээлийн өнгө | 2. Дээлийн гадрыг доторт товхин тогтоохоор нэвт хатгаж, оёсон гулд оёдол |
| c. Дээлийн хаваас | 3. Дээлийн гадна энгэрийн хормой хүртэлх ташуу хөвөө |
| d. Дээлийн сум | 4. Дээлийн гадар хийх бөс бараа |
| e. Дээлийн туурай | 5. Хормойн ташаа залгах хэсгээс дорогш битүүлж оёогүй үлдээсэн ангархай |